



Дорнод аймгийн Аудитын Газар
Үндэсний Аудитын газрын нэгдсэн
төлөвлөгөө, удирдамжийн дагуу
хийсэн нийцлийн аудитын тайлан

**БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САНГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН /ҮАГ-НАГ/2016/03-НА/**

12 дугаар зүйл. Байгаль хамгаалах сан

12.1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө энэ хуулийн 7.1-д зааснаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

12.1.1. тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны хураамж;

12.1.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хуулийн 4.2 дахь хэсэгт заасан мөнгөн хөрөнгө.

12.1.3. ус бохирдуулсны төлбөрийн орлого.

/Энэ заалтыг 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн/

12.1.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас байгаль орчин болон байгалийн нөөц баялагт учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого;

/Энэ заалтыг 2015 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

12.1.5. байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлого;

/Энэ заалтыг 2015 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

12.1.6. хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийг борлуулсны орлого.

/Энэ заалтыг 2015 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмсэн/

“Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”

Дорнод аймгийн хэмжээнд Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Байгаль хамгаалах сангийн журам бүрэн хэрэгжихгүй байна.

**Чойбалсан хот
2016 он**

Агуулга**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймгийн Аудитын
газрын Гүйцэтгэлийн
аудитын баг

Дарга, Тэргүүлэх аудитор
Б.Болортуул
Утас: 70584203

Аудитын менежер
В.Цэнгэлмаа
Утас: 70584207

Ахлах аудитор
Б.Дэлгэрмаа
Утас: 70584207

2016 оны 09 дүгээр сар
Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70584207 дугаарын
утас, 70584203
дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р
байр, 2 давхар 104 тоот

I Бүлэг: Аймгийн хэмжээнд Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Байгаль хамгаалах сангийн журам бүрэн хэрэгжихгүй байна.

II Бүлэг: Сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлээгүй байна.

III Бүлэг: Байгаль хамгаалах санд хууль, журамд заасны дагуу хөрөнгө төвлөрүүлээгүй тул зарцуулалт байхгүй байна.

IV Бүлэг: Сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгддэггүй байна.

ДҮГНЭЛТ**ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН ХАРИУ****ЗӨВЛӨМЖ****ТУШААЛ**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ болон Дорнод аймгийн Аудитын газрын 2016 онд нийлүүлэх аудит, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааны үр дүнд нийцлийн аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааны үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, ҮАГ болон аймгийн холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийлээ.

Үүнд:

- Хууль, эрх зүйн зохицуулалт нь үйл ажиллагааг бүрэн хангаж байгаа эсэх;
- Сангийн хөрөнгийг хуульд заасны дагуу төлөвлөж бүрэн бүрдүүлж байгаа эсэх;
- Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасны дагуу зарцуулж, үр дүн гарч байгаа эсэх;
- Дотоод хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх;

Аудитын хамрах хүрээ

Аудитад аймгийн ЗДТГ, БОАЖГ, Онон Улз болон Буйр нуур Мэнэнгийн талын сав газрын захиргаа, 14 сумдын ЗДТГ-ын сантай холбоотой баримт, материалыг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын удирдамж АДБОУС 4000-4200, ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх, шалгадагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, ярилцлага хийх, анхны баримтаас хөөн шалгах, давтан гүйцэтгэх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудит хийж буй асуудлуудыг нэгтгэж тайланд тусгахдаа дараах арга зүйг ашиглаж баримтжууллаа.

- Аймаг, сумдын байгаль хамгаалах сангийн тайланг үнэн зөв гаргасан эсэхийг үзлээ.
- Сумдын татварын тайланг дансны хуулгуудтай нь тулган шалгалаа.
- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын тайлангуудыг судаллаа.
- Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн байгаль орчин, уул

уурхай, аялал жуулчлалын мэргэжилтэн
Т.Уянгоо, БОАЖГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
С.Мөнхсайхан нараас аудиттай холбогдуулж тодруулга авч, ярилцлага
хийн баталгаажууллаа.

Аудитын стандартын талаарх мэдэгдэл

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- Засгийн газрын 2012 оны 189 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгаль хамгаалах сангийн зохион байгуулалт”.
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, аудитын менежер В.Цэнгэлмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, аймгийн Аудитын газрын гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор Б.Дэлгэрмаа төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа

Аудитыг 2016 оны 08 дугаар сарын 11-ний өдрөөс эхэлж, 09 дүгээр сарын 30-ны өдөр дуусган дарга, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж ҮАГ-ын Нийцлийн аудитын газарт хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын хариу, аудитын зөвлөмж, тайлангийн хавсралт хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурьдсан 4 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлууллаа.

I Бүлэг: Аймгийн хэмжээнд Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Байгаль хамгаалах сангийн журам бүрэн хэрэгжихгүй байна.

Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаа нь Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 2012 оны 189 дүгээр тогтоолоор батлагдсан “Байгаль хамгаалах сангийн зохион байгуулалт”-аар зохицуулагдахаар заасан байна.

Байгаль хамгаалах сангийн данс аймгийн Төрийн сан, 14 сумдад байршиж байгаа боловч Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу эх үүсвэр бүрдээгүй байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд зааснаар Байгаль хамгаалах сангийн хөрөнгө нь “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хуулийн 4.2 дахь хэсэгт заасан мөнгөн хөрөнгө.” гэсэн эх үүсвэрээс бүрдэнэ гэсэн боловч энэ хууль 2012 онд хүчингүй болсон байна.

II Бүлэг: Сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлээгүй байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7.1-д тусгай сан нь дараах нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ гэж заасан байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө
- Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив
- Гадаад улс, олон улсын байгууллагаас Засгийн газрын шугамаар олгосон зээл.

Дээрх эх үүсвэрүүдээс 2015, 2016 онуудад байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрөөгүй байна.

Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12.1-д Байгаль хамгаалах сангийн хөрөнгө энэ хуулийн 7.1-д зааснаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ гэж заасан. Үүнд:

- Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны хураамж.
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хуулийн 4.2 дахь хэсэгт заасан мөнгөн хөрөнгө.
- Ус бохирдуулсны төлбөрийн орлого.
- Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас байгаль орчин болон байгалийн нөөц баялагт учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого.
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлого.
- Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийг борлуулсны орлого.

Дээрх эх үүсвэрүүдээс иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас байгаль орчин болон байгалийн нөөц баялагт учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого, хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийг борлуулсны орлогуудыг өмнөх онуудын дунджаар төлөвлөн бусад орлогуудыг төлөвлөдөггүй байна.

Төлөвлөөгүй эх үүсвэрүүдээс орлого төвлөрүүлэх боломжуудыг судлахад дараах байдалтай байна.

1. Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлал эрхлэх эрхийн бичиг олгосны хураамжийн орлого ороогүй байна. Тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлал эрхлэхээр хүсэлт гаргасан иргэд, аж ахуйн нэгж байхгүй байна.

2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хууль хүчингүй болсон байна.

3. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль нь 2012.05.17-ны өдөр батлагдсан. Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээг усны сав газар тус бүрээр усны экологи- эдийн засгийн үнэлгээг үндэслэн энэ хуулийн 7.1-д заасан хязгаарт багтаан тогтоохоор хуулинд заасан байна. Дээрх ус бохирдуулсны төлбөрийг тооцох журам одоогийн байдлаар батлагдаагүй байгаа учраас ус бохирдуулсаны төлбөр тооцогдоогүй байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагчдаас энэ хуульд заасны дагуу тусгай санд төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийн хэмжээг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу хянаж, тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл болон улсын төсвийн төсөлд тусгана.” гэж заасан боловч хэрэгжээгүй байна.

Байгаль хамгаалах санг 2015, 2016 онуудад дээрх эх үүсвэрүүдээс бүрдүүлсэн эсэхийг шалгахад дараах байдалтай байна.

Аймгийн төрийн санд байгаль хамгаалах сангийн данс байршиж байгаа боловч Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу эх үүсвэр бүрдээгүй, 2015, 2016 онуудад гүйлгээ гараагүй болох нь дансны хуулгаар нотлогдож байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан байгаль хамгаалах санд орох эх үүсвэрүүд сумдын байгаль хамгаалах сангийн дансанд ордоггүй сумдад зөвхөн 2014 онд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А-05 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам”-ын 1.3-т “.....байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгааны мөнгөн хөрөнгийг тухайн төсөл хэрэгжих сум, дүүргийн нөхөн сэргээлтийн тусгай дансанд байршуулна.” гэж заасны дагуу 14 сум байгаль хамгаалах сан гэсэн тусгай дансыг нээж 2015 оноос эхлэн тус дансанд байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийг байршуулж байна. Аймгийн 11 сумдын байгаль хамгаалах сангийн дансанд энэ оны 9 дүгээр сарын 01-ний байдлаар 87,0 сая төгрөгийн нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгө байршиж байна.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас байгаль орчин болон байгалийн нөөц баялагт учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого 2015 онд 29,7 сая төгрөг, 2016 онд 12,3 сая төгрөг нийт 42,0 сая төгрөг аймаг, сумдын татварын бусад орлого болон хүү, торгуулийн орлогод орсон байна. Энэ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 1-д “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчин болон байгалийн нөөцөд хохирол учруулсан бол нөхөн төлбөр төлөх бөгөөд нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан Байгаль хамгаалах санд оруулна. Нөхөн төлбөр төлөгч нь тогтоосон хэмжээнээс илүү төлбөр төлсөн тохиолдолд зөрүүг Байгаль хамгаалах сангаас буцаан олгоно.” гэж заасантай нийцэхгүй байна.

Мөн хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийг борлуулсны орлого 2015 онд 16,4 сая төгрөг, 2016 онд 55,1 сая төгрөг нийт 71,5 сая төгрөг сумдын татварын бусад орлого болон хүү, торгуулийн орлогод орсон байна.

Байгаль хамгаалах сангийн орлого нь хууль болон Байгаль хамгаалах сангийн тухай журмын дагуу төвлөрдөггүй байна.

III Бүлэг: Байгаль хамгаалах санд хууль, журамд заасны дагуу хөрөнгө төвлөрүүлээгүй тул зарцуулалт байхгүй байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 12.2-д “Энэ хуулийн 12.1-д заасан сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна” гэж заасан. Үүнд:

- байгалийн баялгийн нөөц, байгаль орчны төлөв байдлын хувьсал, өөрчлөлтийн байдлыг судлан тогтоох, мэдээллийг хуримтлуулж боловсруулах, дүгнэлт гаргах төсөл, арга хэмжээ
- байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг багасгах дэвшилт арга, хоргүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг урамшуулах
- байгаль орчныг хамгаалахтай холбогдсон асуудлаар үндэсний болон олон улсын семинар, онол, практикийн бага хурал, уулзалт, симпозиум зэрэг арга хэмжээг зохион байгуулах
- байгаль орчныг хамгаалах, хянах, судлахад шаардагдах техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хэмжих багаж худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх
- байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, сурталчлах, шинжлэн судлах үйл хэрэгт онцгой амжилт гаргасан өөрийн улсын болон гадаадын иргэдийг шагнах
- байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах
- байгаль орчныг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаа явуулах
- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг дэмжих
- байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэхэд бодит туслалцаа үзүүлсэн болон илрүүлсэн нөхөрлөл, төрийн бус байгууллага, цагдаа, хил хамгаалах байгууллагын ажилтныг урамшуулах байгаль

хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөхөд шаардлагатай үнэлгээ, шинжилгээ, шинжээчийн болон лабораторийн зардал гэж заасан байна.

Гэтэл Байгаль хамгаалах санд хууль, журманд заасны дагуу хөрөнгө төвлөрүүлээгүй тул дээрх хуулийн заалт хэрэгжихгүй байна.

Сумдын төсвийн орлогод орсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас байгаль орчин болон байгалийн нөөц баялагт учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого, хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийг борлуулсны орлогууд нь дээрх арга хэмжээнд зарцуулагдахгүй төсвийн байгууллагын санхүүгийн дэмжлэгэд зарцуулагдаж байна.

IV Бүлэг: Сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгддэггүй байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 30.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь тусгай сангийн зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан тайланд тусган санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.”, 31.1-д “Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан журмын дагуу тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт, шалгалт хийнэ.” гэж заасан байна.

Сумдууд сангийн санхүүгийн тайланг сумын төрийн сангийн нэгтгэлд хуулийн дагуу нэгтгүүлдэг байна.

Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба хяналт шалгалт хийх үүрэгтэй байна.

Байгаль хамгаалах санд 2015, 2016 онуудад дотоод хяналт хийгдээгүй байна.

Аймгийн Төрийн сан, сумдын ЗДТГ, Байгаль орчин, аялал жуулчлалын газар шилэн дансны мэдээллийг хуульд заасны дагуу мэдээлж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль, журмууд нь хоорондоо нийцэхгүй байна.
2. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Байгаль хамгаалах сангийн журам аймагт бүрэн хэрэгжихгүй байна.
3. Сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөөгүй байна.
4. Байгаль хамгаалах сангийн орлогыг хууль, журамд заасны дагуу төвлөрүүлээгүй байна.
5. Байгаль хамгаалах санд хөрөнгө төвлөрөөгүй тул зарцуулалт байхгүй байна.
6. Сангийн үйл ажиллагаанд хуулийн дагуу хийгдэх дотоод хяналт шалгалт хийгддэггүй байна.

МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА21000, Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, факс: 7058-4584

2016.10.06 № 1/1621

танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ХАРЬЯА
ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааны үр дүн болон байгаль орчны хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын гаргасан дүгнэлт, зөвлөмжийг хүлээн авч танилцлаа.

Танай ирүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн дагуу үе шаттай ажил зохион байгуулж ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА



М.БАДАМСҮРЭН

01 519



ДОРНОД АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

21075, Чойболсан, Дорнод аймаг
Утас/Факс: 7058-3529


2016-09-27 № 110

танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх сан болон
байгаль орчны багц хуулийн хэрэгжилт сэдвээр
хийсэн нийцлийн аудитаар өгсөн дүгнэлт
зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллана.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Мөнхсайхан* С.МӨНХСАЙХАН



23 223

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, БОАЖГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Мөнхсайхан нарт:

1. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Байгаль хамгаалах сангийн журмыг хэрэгжүүлж ажиллах.
2. Сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөх.
3. Сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлэх.
4. Сангийн хөрөнгийг төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулж байх.
5. Сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хийх.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2016 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 22

Чойбалсан хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаал, 2003 оны 53 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах тухай журам"-ын 4.2 дахь заалт, аймгийн Аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, төлөвлөгөөний дагуу Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн "Байгаль хамгаалах сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан", Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитын тайлангуудыг баталсугай.

2. Аудитаар тавигдсан төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайлангуудыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Алтанзул, аймгийн ИТХ-ын дарга Л.Хишигтогтох, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, БОАЖГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Мөнхсайхан, Политехник коллежийн захирал Д.Энхжаргал, МСҮТ-ийн захирал Т.Гантулга нарт тус тус хүргүүлсүгэй.

4. Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер В.Цэнгэлмаад даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

11 166

Аудитаар тавигдсан зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2016 оны 11 дүгээр сарын 30-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэх.

